



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС  
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилах тухай**

Говь ХК-ийн 2018 оны санхүүгийн үр дүнг харгалзан, компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцаанд ногдол ашиг хуваарилах нь зүйтэй гэж үзэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 8.9 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

**Нэг.** Говь ХК-ийн 2018 оны цэвэр ашгаас хувьцааны нэгж тутамд 6.8 (Зургаан төгрөг нэгж мөнгө.....) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтоож, ногдол ашгийг 2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгон, 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д даалгасугай.

**Хоёр.** Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

**Гурав.** Компанийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахтай холбоотой гарах зардлыг холбогдох зардлын төсвөөс гаргахыг Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан-д зөвшөөрсүгэй.

**Дөрөв.** Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн талаарх мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД



*[Signature]*

Д.ГЭРЭЛМАА

*[Signature]*

Ц.БААТАРСАЙХАН

*[Signature]*

М.БАЯР

*[Signature]*

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС  
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

20.19 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

З.ШАГДАРСУРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН